



## АХИЦ ДЭВШЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр:	Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль
Хөтөлбөрийн нэр:	Найруулах урлаг- D02
Шинжээч:	Шинжээч: Р.Чанцалдулам- ХААИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал, Ph.D

2022 оны 06 сарын 03

## АГУУЛГА

Хөтөлбөрийн танилцуулга .....	4
Зөвлөмжийн дагуу:	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт .....	5
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа .....	5
Шалгуур 3. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц .....	6
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .....	6
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ .....	7
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн .....	8
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт .....	10
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал .....	11
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

## 1. Үйл явц, төлөвлөлт

Сургууль	СУИС-ийн Театрын урлагийн сургууль	
Хөтөлбөр	Найруулах урлаг бакалавр	
Магадлан итгэмжлэгдсэн	ДБМИК-ийн 2021.04.26-ны өдрийн 03 дугаар тогтоол	
Үнэлгээний баг	Шинжээч	Р.Чанцалдулам ХААИС-ийн сургалт эрхэлсэн захирал
Төлөвлөгөө	<b>Өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2022.05.24	Шинжээч томилох
	2022.06.02	Багийн гишүүнд ахиц дэвшлийн тайланг хүлээлгэн өгөх
	2022.06.07	Шинжээч сургуульд ажилласан
	2022.06.25	Шинжээч тайлан, дүгнэлтээ ирүүлэх
	2022.07.06	Шинжээчийн тайланг эцсийн байдлаар бэлэн болох
Үндэслэл	Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2.2, 5.1.2 дахь заалт; Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирлын 2022 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн А/116 тоот тушаал	

## 2. Найруулах урлаг хөтөлбөрт ДБМИК-оос өгсөн зөвлөмж

Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 04 дугаар сарын 26-ны 03 дугаар тогтоолын хавсралтаар дараах шаардлага, зөвлөмжийг өгсөн. Үүнд:

Нэг. Шаардлага:	
Шалгуур 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд	-Хөтөлбөрийн хүрэх үр дүн болох PLOs хүрч чадаж байгаа талаарх судалгаа, хөндлөнгийн үнэлгээ дутмаг байгааг анхаарч төгсөгчийн хүрэх үр дүнг үйлээр илэрхийлэн зөв тодорхойлох; -Төгсөгчийн загварыг дахин тодорхойлох; -Мэргэжлийн багш нарын хавтас, сургалтын хэрэглэгдэхүүний баримт бичгийн бүрдлийг сайжруулах;
Шалгуур 2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга түүний шинэчлэл	-Сургалтын хөтөлбөрийн үндсэн баримт бичигт сайжруулалт хийх;
Шалгуур 3.2 сургалтын хэрэглэгдэхүүн	-Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сурах бичгийг орчуулан сургалтад хэрэглэх албан ёсны зөвшөөрөл авахад сургуулийн зүгээс анхаарч ажиллах;
Шалгуур 3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр	-Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сурах бичгийг орчуулан сургалтад хэрэглэх абан ёсны зөвшөөрөл авахад сургуулийн зүгээс анхаарч ажиллах; -Мэргэжлийн багш нарыг сурах бичиг бичихэд нь удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах;

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	-Найруулах урлагийн тэнхимийн үндсэн багш нарын докторын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлэх; -Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны бүтээлийг гадаадын инфакт фактор (IF) өндөртэй сэтгүүлд хэвлүүлэх талаар анхаарч ажиллах; -Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлэх;
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	-Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх -Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг үнэлэх шууд болон шууд бус өөрийн үнэлгээний аргазүйг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх -Хөтөлбөрийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийх

### Нэг. Найруулах урлагийн бакалаврын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн дэргэд А.Никитиний удирдсан үндэсний Найруулагчийн анги нээн Монгол улсад дээд боловсролтой найруулагч бэлтгэж эхэлсэн. Зөвхөн ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүд ирдэг байсан Кинодрамын тэнхимд цаг үе, нийгмийн шаардлагаар олон улсад мэргэжил дээшлүүлсэн багш нар ирж ажилласан нь сургалтын хөтөлбөр сайжрахад нөлөөлсөн. 1971 оноос уран чадварын багшаар Д.Маамхүү, 1975-1990 онд Б.Мөнхдорж, 1980-1986 онд Г.Доржсамбуу зэрэг нэр хүндтэй найруулагчид багшлах болсноор тэнхимийн чадавх, сургалтын чанар сайжирчээ. Кино-драмын найруулагч, жүжигчин бэлтгэх сургалтад К.С.Станиславскийн системийг үндэс болгож, үе үеийн тэнхимийн эрхлэгчид, багш нар сургалтын агуулга, чанарыг нийгэм, эдийн засгийн хөгжил, дэвшил, төрийн бодлоготой уялдуулан байнга шинэчлэн сайжруулсаар иржээ. 1990 онд Соёл урлагийн дээд сургууль байгуулагдахад Найруулагч, жүжигчний уран чадварын тэнхим нийгэм, эдийн засгийн тогтолцоог ардчилал, зах зээлийн харилцаанд шилжүүлэх өөрчлөлт, шинэчлэлт, төрийн бодлогод уялдуулан 1992-1998 онд найруулагч бэлтгэх сургалтын агуулга, стандартыг боловсруулах үйл явц явагдаж сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, мэргэжлийн тодорхойлолт зэргийг хянан үзэж, шинэ үзэл санаа, агуулгаар баяжуулан мөрдсөн.

Шинжээчийн багийн зөвлөмжийн дагуу сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, агуулгыг боловсронгуй болгох, нэгж хичээлийн стандарт хөтөлбөрийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх, багш, оюутны эрдэм шинжилгээний ажлын цар хүрээ, өгөөжийг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажилласан байна.

## ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

### Шалгуур 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

#### **Шаардлага 1.** Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

##### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Хөтөлбөрийн баримт бичгийн хувьд дараах шинэчлэлт, сайжруулалтыг хийсэн нь нотлох баримтаар баталгаажсан. Үүнд:

1. Хөтөлбөрийн баримт бичиг 2022 он.
2. Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг уран сайхны бүтээлд судалгаа хийдэг, шинийг санаачлагч, бүтээлч ёс зүйтэй, тайз дэлгэцийн салбарт хөрвөх чадвартай, зохион байгуулагч, манлайлагч найруулагч байхаар дахин тодорхойлсон.
3. “Найруулах урлаг” бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчийн суралцах хугацаандаа олж авах мэдлэг, ур чадвар, хандлагыг Блумын таксономын үйлийн системчилсэн ангилалтай уялдуулан тодорхойлсон.
4. Хөтөлбөр боловсруулах, агуулгыг сайжруулах талаар арга зүйн зөвлөгөөг авч, “Үр дүнд суурилсан боловсрол” сургалтыг удаа дараа зохион байгуулсан.

##### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй сайжруулах
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнг уялдуулах

**Шалгуурын хангасан байдал:** Бүрэн хангасан

### ШАЛГУУР ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### **Шаардлага 2.** Сургалтын хөтөлбөрийн үндсэн баримт бичигт сайжруулалтыг хийх

##### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Тухайн хөтөлбөрийн үндсэн баримт бичигт дараах сайжруулалтыг хийсэн байна. Үүнд:

- СУИС-ийн захирлын 2022 оны А/203 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо Блумын таксономын үйлийн системчилсэн ангилалтай уялдуулан тогтоосон.
- Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLO)-г хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх аргазүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулсан.

- Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын уялдаа холбооны зураглалыг гаргаж улирал бүр үзэх хичээлүүд ба хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн хамаарлыг илүү дэлгэрэнгүй байдлаар тодорхойлохын тулд ITUA загвар ашиглан боловсруулсан.

### **Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР ГУРАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ**

**Шаардлага 1.** Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сурах бичгийг орчуулан сургалтад хэрэглэх албан ёсны зөвшөөрөл авахад сургуулийн зүгээс анхаарч ажиллах;

### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулж дараах байдлаар ажилласан байна. Үүнд:

- ОХУ-ын Москва хотын Театрын урлагийн дээд сургуулиас /ГИТИС/ эрхлэн гаргасан С.В.Женовач, Н.А.Зверева, О.Л.Кудряшов нарын хамтран бүтээл “Мастерство режиссура” найруулах урлаг сурах бичгийг тус сургуулиас орчуулан хэрэглэх хүсэлтийг илгээж зөвшөөрөл авсан.

**Шаардлага 2.** Мэргэжлийн багш нарыг сурах бичиг бичихэд нь удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлдэг байх:

- Захирлын тушаалаар томилсон сурах бичиг, гарын авлага орчуулах орчуулгын баг нь 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын хэрэглэгдэхүүнд хэрэглэх 5 дэвтэр бүхий цуврал гарын авлагыг орчуулан хэвлүүлсэн.

**Зөвлөмж 1.** Хамтран ажилладаг олон улсын сургуулиудтай мэргэжлийн сурах бичиг нэвтрүүлэх тал дэр тусгайлан ажиллах;

**Зөвлөмж 2.** Тэнхимийн багш нар гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийг Монгол хэл рүү орчуулж сургалтад ашиглах тал дээрх анхаарах.

### **Зөвлөмжийн дагуу хийсэн ажлууд:**

- Багш нарт зориулсан “Мэргэжлийн сурах бичиг, гарын авлага боловсруулах аргазүй” сургалтыг зохион байгуулсан.
- 2020 оны байдлаар нийт 19,046,760 төгрөгийн үнэ бүхий нийт 350 нэр төрлийн 1200 ном, 2021 оны байдлаар нийт 32,470,873 төгрөгийн нийт 373 нэр төрлийн 1288 номын фондтой болж тус тус өссөн ба хооронд нь харьцуулбал нийт **7 хувиар** номын фонд өссөн.
- “Найруулах урлаг” болон “Жүжиглэх урлаг” хөтөлбөрт хамаарагдах ном 2020 оны байдлаар 180 нэр төрлийн 556 ширхэг ном, 2021 оны байдлаар 203 нэр төрлийн 644 ширхэг ном тус тус байна. Мөн эдгээр хөтөлбөртэй холбоотой орос хэл дээрх 84 ширхэг ном шинээр бүртгэсэн.
- 2020-2021 оны хичээлийн жилд СУИС-ийн төв номын сан нь цахим номын сангийн ажлын хүрээнд 233 номыг цахим хэлбэрт шилжүүлж Open.mnuac.edu.mn байршуулсан.

## Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан

### ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**Зөвлөмж:** ТУС-ийн төгсөгчдийн холбоог байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах

**Зөвлөмжийн дагуу хийсэн ажлууд:**

**Илрэл нотолгоо:**

Тус хөтөлбөр нь 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Театрын урлагийн сургуулийн төгсөгчдийн холбоо гэсэн оноосон нэртэй ТББ-ыг үүсгэн байгуулсан. Уг холбоо нь ТУС-ийн төгсөгчдийг эвлэлдүүлэн нэгтгэх, эрх ашгийг хамгаалах, тодорхой уран бүтээлийн үйл ажиллагаа санаачлах, бэхжүүлэх, төсөл хөтөлбөр зохион байгуулах, сургууль төгсөгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөтгөх зорилготой. Холбооны ерөнхийлөгчөөр Д.Амгаланбаяр томилогдсон байна. Төгсөгчдийн холбооны дүрмийг баталсан. Одоогоор төгсөгчдийн холбоондоо төгсөгчдөө элсүүлэх үйл ажиллагаа явагдаж байна. Төгсөгчдийн холбоо нь сургуулийн оюутны волейбол, сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний үеэр төгсөгчдийн төлөөлөл нөхөрсөг тоглолт хийж үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

**Зөвлөмж:** Найруулагч болох сонирхолтой иргэдэд уг хөтөлбөрөөр суралцах боломжийг хангах талаар хууль, эрх зүйн зохицуулалтыг хийхэд удирдлагын зүгээс анхаарч ажиллах

**Зөвлөмжийн дагуу хийсэн ажлууд:**

**Илрэл нотолгоо:**

Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 14-үний өдрийн А/47 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журамд нэмэлт өөрчөлт оруулах тухай” журмын 4.6-р заалтад “Элсэлтийн ерөнхий шалгалтын хоёр дахь хичээлийг ур чадварын шалгалтаар тооцох мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн жагсаалтыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, 7.1.7-д заасан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх мэргэжлийн чиглэл /хөтөлбөр-ээр элсэх тухайн салбартаа 3-аас доошгүй жил ажилласан 30-аас дээш насны иргэн” гэсэн заалтууд орсон нь найруулагч болох сонирхолтой иргэдэд уг хөтөлбөрөөр суралцахад хууль, эрх зүйн талаасаа боломж бүрдсэн байна.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн холбогдох журамд хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоо үүргийг тодорхой болгох;

## Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан

### ШАЛГУУР 5. СУРАЛЦАГДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

**Зөвлөмж:** Ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын орчин, багшлах боловсон хүчин гэх зэрэг боломжууд дээр тулгуурлаж элсэлтийн тоог харгалзан үзэх

**Зөвлөмжийн дагуу хийсэн ажлууд:**

### **Илрэл нотолгоо:**

2021- оны хичээлийн жилд тус хөтөлбөрт 6 оюутан элсэн суралцсан. Тус сургуулийн Захиргааны зөвлөлийн удаа дараагийн хурлуудаар “Найруулах урлаг” хөтөлбөрт жилд элсэх элсэгчдийн тоог сургалтын орчин, багшлах боловсон хүчин зэрэг боломжуудыг харгалзан жилдээ 10 хүртэлх оюутан элсүүлэн суралцуулж байхаар хэлэлцсэн байна. СУИС-аас элсэгчдийн хяналтын тоон дээр сургууль тус бүрээс санал авч шийдвэрлэдэг. СУИС-ийн Удирдах зөвлөлийн “Элсэгчдийн хяналтын тоог батлах тухай” 2021 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн 03 тоот тогтоолын хавсралтаар тус хөтөлбөрийн элсэгчдийн хяналтын тоо 10 байхаар батлагдсан нь баримтаар нотлогдож байна.

**Зөвлөмж:** Найруулагчийн мэргэжлээр сонгон элсүүлэх шалгуур үзүүлэлтийг онолын үндэслэл бүхий сургалтын программ дээр үндэслэн тогтоох нь зүйтэй.

### **Зөвлөмжийн дагуу хийсэн ажлууд:**

#### **Илрэл нотолгоо:**

Соёл урлагийн их сургуулийн захирлын 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2022 онд оюутан элсүүлэх журмыг батлах тухай” тушаалаар тус хөтөлбөрт элсүүлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлон баталжээ. Ур чадварын шалгалт нь ерөнхий чадвар, онцлог чадвар гэж 2 шатлалттай бөгөөд **ерөнхий чадварын шалгалтад** өөрийн судалбар, хөдөлгөөний эвсэл, бүжиг, дуулах чадвар, сонсгол ритм, ёгт үлгэр ярих зэрэг чадвараар тэнцсэн суралцагчид онцлог чадварын шалгалт өгдөг байна. **Онцлог чадварын шалгалтад** уран сэтгэмж, өгөгдсөн судалбар, ярилцлага, оюуны чадамжийн шалгалтыг тус тус авахаар баталсан байна.

**Шалгуурын хангасан байдал:** Бүрэн хангасан

### **ШАЛГУУР 6: БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Шаардлага 1.** Найруулах урлагийн тэнхимийн үндсэн багшийн докторын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлэх

**Шаардлага 2.** Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны бүтээлийг гадаадын импакт фактор өндөртэй сэтгүүлд хэвлүүлэх талаар анхаарч ажиллах

**Зөвлөмж 1.** Хөтөлбөрийн мэргэжлийн үндсэн багшийн тоог нэмэгдүүлж, ерөнхий эрдмийн хичээлийн тоог эргэн харж зохицуулалт хийх

### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Эрдэмтэн багшийн тоог нэмэгдүүлэхэд дараах байдлаар анхаарч ажилласан байна. Үүнд:

1. Одоогийн байдлаар, нийт багш /үндсэн болон гэрээт/-ийн дунд эрдмийн болон мэргэжлийн өндөр зэрэгтэй багшийн эзлэх хувь 31.1%-тай байна. Үүнээс, доктор, дэд профессор, хүндэт профессор багшийн эзлэх хувь 56%-тай байна. Ахиц дэвшлийн хугацаанд:



- a. С. Болормаа багш СУИС-д урлаг судлалын чиглэлээр “Монголын драмын урлаг дахь театрын хэлбэршил” сэдвээр докторын зэрэг 2021 онд хамгаалсан.
  - b. Р. Нацагдоо ОХУ-ын Санкт-Петербургийн ТУА
  - c. А. Баярмэнд ОХУ-ын Санкт-Петербург хот дахь Урлаг судлалын дээд сургуульд (РИИИ) урлаг судлалын чиглэлээр хамгаалахаар явсан.
2. Хөтөлбөрийн багш нарын хувьд эрдэм шинжилгээний хуралд бүрэлдэхүүний сургуулийн хэмжээнд 25, их сургуулийн хэмжээнд 5, үндэсний хэмжээнд 4 олон улсын хэмжээнд 8 тус тус хэлэлцүүлсэн.
  3. Олон улсын инфакт фактортой сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл одоогоор байхгүй байна.
- Хүснэгт 1. Зохион байгуулсан, оролцсон эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлсэн илтгэлийн нэр /2020-2022 он/

№	Илтгэл хэлэлцүүлсэн багш	Илтгэлийн нэр	Огноо	Хаанаас зохион байгуулсан
<b>Нэг. ТУС-ийн Багш нарын эрдэм шинжилгээний хурал-2020</b>				
1	Б.Бат-Өлзий	“Морь уналгын эрдмийг тайзны хөдөлгөөний хичээлд нэвтрүүлэх нь”	2020.	ТУС, Судалгааны профессорын баг
2	Б.Болдбаатар	Жүжиг, киноны зохиолын үзэгдлийг бүтээх нь		
3	М.Ариунжолоо	“Туйлын зорилго дүрийн гол шугамыг хөтлөх нь”		
4	Х.Чойдогжамц	Орон нутгийн театруудын дуулалт жүжгийн хөгжлийн асуудалд (Ховд, Баян-өлгий, Завхан аймгийн хөгжимт жүжгийн театрын жишээн дээр)		
5	У.Дэлгэрбуян	“В.Э.Мейерхольдын нөхцөлт театрын аргачлал орчин үеийн театрын найруулгын чиг хандлага болох нь”		
6	Ж.Болор-Эрдэнэ	Оюутны бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх аргын хэрэглээ		
7	Д.Долгоржав	“Хэмнэл” (Жүжигчний хөгжмийн боловсролд зориулсан гарын авлагын жишээнд)		
8	Г.Тунгалаг	Орон нутгийн театрын санхүүжилттэй холбоотой зарим асуудал		
9	Б.Энхгэрэл	Үг урлаач МУАЖ Г.Равдангийн уран чадварыг шинжихүй		
<b>Хоёр. ТУС-ийн Багш нарын эрдэм шинжилгээний хурал-2021</b>				
1.	М.Ариунжолоо	“Орчин үеийн театрын жүжигчний сургалтад дүрийг судалбарын аргаар судлах аргачлалыг ашиглах нь” /К.С.Станиславский, Н.В.Демидов/	2020.11.09	ТУС, Судалгааны профессорын баг

2.	Р.Нацагдоо	Ю.А.Васильевын аргачлалыг сургалтад нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага, боломж		
3.	Б.Болдбаатар	"Зохиолын төлөвлөгөөнд үйлдлийн цохилт (beat ) ашиглах нь"		
4.	Х.Чойдогжамц	"Орон нутгийн театруудын дуулалт жүжгийн хөгжлийн асуудалд /Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын ХЖТ-ын жишээнд/		

### Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан

## ШАЛГУУР ДОЛОО. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТ

**Шаардлага 1.** Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх;

**Шаардлага 2.** Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг үнэлэх шууд болон шууд бус өөрийн үнэлгээний аргазүйг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх

**Шаардлага 3.** Хөтөлбөрийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийх;

**Зөвлөмж 1.** Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгааг тогтмолжуулж мэдээллийн санг үүсгэх шаардлагатай.

### Баримт нотолгоо, үнэлгээ:

Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг дараах байдлаар анхаарч ажилласан байна Үүнд:

1. “Соёл урлагийн их сургуулийн үйл ажиллагаанд тэргүүн туршлага нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлэх” төслийг хэрэгжүүлсэн.
2. Сургалтын чанарын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх ажлын хүрээнд “Үр дүнд суурилсан боловсролын стандарт, арга зүйг түгээн дэлгэрүүлэх” шат дараатай сургалтууд авч ажилласан.
3. СУИС-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод чанарын баталгаажуулалт 2022 оны жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.

### Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан

## ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

- ✓ 2021 онд “Найруулах урлаг” бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлснээс хойш хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг шинэчлэн тодорхойлохдоо Блумын таксономын үйлийн системчилсэн ангилалтай уялдуулан тодорхойлсон байна.
- ✓ 2020 онд төгсөгчийн загварыг шинэчлэн боловсруулсан.
- ✓ Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан ганцаарчилсан хичээлийн цагийг нэмэгдүүлсэн байна. Хөтөлбөрийг дадлагад суурилсан арга барилаар сайжруулан дадлага, төсөл, уран бүтээл, үйлдвэрлэлийн орчныг сайжруулахад ахиц амжилт гаргажээ.
- ✓ Сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн стандарт хөтөлбөрийн загварыг шинээр боловсруулсан. Уг хичээлийн загварт тухайн хичээл бүрийн суралцахуйн үр дүнг дэлгэрэнгүй тодорхойлж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдуулсан нь давуу талыг харуулж байна.
- ✓ Багш нарын эрдмийн зэрэг, цолыг ахиулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр бодлого, зохион байгуулалт, санхүүжилтээр дэмжин ажилласнаар доктор, магистр багш нарын тоо нэмэгдэж, багш нарын бүтээл мэргэжлийн ном, сурах бичиг нэмэгдсэн байна.
- ✓ ДБМИК-ийн 2018 оны 66 дугаар тогтоолоор уг хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр өгсөн 9 зөвлөмжийн 7 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хангалттай гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлж байна гэж дүгнэж байна.

Шалгуур		Бүрэн хангасан 2	Хэсэгчлэн хангасан 1	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	4			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	2			Бүрэн хангасан

7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	3			<b>Бүрэн хангасан</b>
	Нийт	26			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Шинжээч ..... Р.Чанцалдулам

Сургуулиас ирсэн албан бичиг:



**СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ  
ТЕАТРЫН УРЛАГИЙН СУРГУУЛЬ**


15140 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 26, Утас: 32-41-37, Факс: +976-31-56-05

2022. 07. 05 № 01/88  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Тус сургуулийн “Найруулах урлаг” хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчийн баг 2022 оны 06-р сарын 03-ны өдөр сургууль дээр ажилласан.

Дээрх ажлын хүрээнд гаргасан шинжээчийн багийн тайланг 2022 оны 07-р сарын 04-ны өдөр хүлээн авч, тус сургуулийн захиргаа, хамт олон танилцсан бөгөөд хүлээн зөвшөөрч байгааг үүгээр уламжилж байна.

ЗАХИРАЛ  Д.ДАВААСҮРЭН

